



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 4/222

Өмнөдэлгэр сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам”-ын 11.10 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ний 74 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 5 дугаар сарын 06-ний 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын 2025 оны А/303 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг дүгнэлтийг үндэслэн газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтад ялагч болсон 1 (нэг) малчдын хоршоонд хавсралтад заасан газрыг эзэмшүүлсүгэй.

2.Малчдын хоршоонд эзэмшүүлсэн нэгж талбарыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэж, газар эзэмших эрхийн эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж, газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээг баталгаажуулыг Газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.

3.Газрыг зориулалтын дагуу ашиглаж, гэрээнд заасан нөхцөл, болзлын хүрээнд газрын төлбөрийг хугацаанд төлөхийг газар эзэмшигч малчдын хоршоонд даалгасугай.



Р.ЭНХТӨР

Уг хуулийг Засаг даргын 2025 дүгээр сарын 1-ны өдөр аар захирамжийн хавс

ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ХУГАЦАА

№	Газар эзэмшигчийн нэр (хоршоо)	Регистрийн дугаар	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Хэмжээ м.кв (га)	Зориулалт	Эзэмшүүлэх хугацаа /жил/ 15
1	Өмнөдэлгэрэх булаг хоршоо	4207211	4729090	Булганы үзүүр	5000	Мал аж ахуйн үйлдвэрлэл	
						Дүн	5000